



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах
тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 35.1.4 дэх заалт, Улсын Их Хурлын 2019 оны 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны Захиргаа, удирдлагын газрын албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажил албан тушаалыг хэвээр хадгалах зорилгоор 2020 оны 05 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны болон Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын албан тушаалын жагсаалт"-ын Захиргаа, удирдлагын газрын албан тушаалын жагсаалтыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2.Албан тушаалын жагсаалтыг өөрчлөн баталсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Захиргаа, удирдлагын газарт даалгасугай.


АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.САНЖРАГЧАА

20008157

Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын
2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн
А/30 дугаар тушаалын хавсралт



Захиргаа удирдлагын газрын
албан тушаалын жагсаалт

| д/д | Захиргаа удирдлагын газар | Орон тоо |
|-----|------------------------------------------------------------------------|----------|
| 1 | Захиргаа удирдлагын газрын дарга | 1 |
| 2 | Стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага хариуцсан ахлах референт | 1 |
| 3 | Гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөрийн үр нөлөө хариуцсан референт | 1 |
| 4 | Хууль, эрх зүйн асуудал хариуцсан референт | 1 |
| 5 | Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн | 1 |
| 6 | Зөвлөлийн хуралдааны үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн | 2 |
| 7 | Төсвийн ерөнхий нягтлан бодогч /ахлах мэргэжилтэн/ | 1 |
| 8 | Мэдээллийн технологийн инженер | 1 |
| 9 | Олон нийттэй харилцах ажилтан | 1 |
| 10 | Шуурхай ажлын зохион байгуулалт хариуцсан ажилтан | 1 |
| 11 | Санхүү, бүртгэлийн ажилтан /нярав/ | 1 |
| 12 | Архивын эрхлэгч | 1 |
| 13 | Бичиг хэргийн ажилтан | 1 |
| 14 | Хангамж үйлчилгээний ажилтан | 1 |

--- о О о ---